

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/01/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:

www.audit.mn

Булган хот

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг:
Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Enhtsoodol@audit.gov.mn

Аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342495 Цахим хаяг:
Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	2-3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.15 № 663
танай _____ ны № _____ т

ИЛЧИТ ХУТАГ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Илчит хутаг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Шатахууны зардлаас анхан шатны баримтгүй нийт 1,834.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Бараа материалын тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.5, НББ-ийн тухай хуулийн 12.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй байна.
- Нийт 755.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дахь

006020:65

заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалтыг зөрчин нийт 500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Илчит хутаг ОНБААТҮГ-ын төсвийн шууд захирагч нь 2022 онд Хутаг-Өндөр сумын Засаг даргатай хамран ажиллах гэрээг 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 85 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	68,655,593.70	70,955,777.16
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	24,295,082.79	31,347,955.91
4	Дансны авлага	19,913,171.22	15,632,477.06
6	Бараа материал	24,447,339.69	21,875,344.19
9	Эргэлтийн хөрөнгийн дүн	68,655,593.70	70,955,777.16
11	Үндсэн хөрөнгө барилга	3,983,077,800.40	3,788,173,850.80
12	Биет бус хөрөнгө	4,538,833.35	4,050,000.04
13	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,987,616,633.75	3,792,223,850.84
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,056,272,227.45	3,863,179,628.00
18	Татварын өр	634,785.30	4,230,667.77
21	Бусад богино хугацаат өр төлбөр	1,588,561.23	48,278,561.23
22	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,223,346.53	52,664,749.46
23	Өр төлбөрийн нийт дүн	2,223,346.53	52,664,749.46
25	Өмч: а) төрийн	4,405,291,861.00	4,405,291,861.00
26	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,378,191.00	20,378,191.00
28	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-371,621,171.08	-615,155,173.46
29	Эздийн өмчийн дүн	4,054,048,880.92	3,810,514,878.54
30	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,056,272,227.45	3,863,179,628.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	570,692,603.19	567,795,866.80
2	Борлуулалтын өртөг	105,642,271.27	210,542,010.50
3	Нийт ашиг	465,050,331.92	357,253,856.30
5	Бусад орлого	120,997,000.00	16,958,400.00
7	Ерөнхий ба удирдлагын зардал	592,893,403.76	577,078,625.35
9	Бусад зардал	928,020.00	1,959,300.00
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-8,270,234.87	-243,534,002.38
15	Татвар дараах ашиг (алдагдал)	-8,270,234.87	-243,534,002.38
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-8,270,234.87	-243,534,002.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	618,525,978.55	647,877,889.45
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	567,004,136.37	583,795,866.80
6	Бусад мөнгөн орлого	51,521,842.18	64,082,022.65
7	Мөнгөн зарлагын дүн (-)	620,930,722.78	640,825,016.33
8	Ажиллагчдад төлсөн	172,803,815.00	180,072,681.00
9	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,122,017.39	51,775,679.58
10	Бараа материалын худалдан авахад төлсөн	128,216,622.61	139,092,647.85
11	Ашиглалтын зардалд төлсөн	510,779.09	154,501,711.70
14	Татварын байгууллагад төлсөн	66,922,724.89	71,404,700.63
16	Бусад мөнгөн зарлага	75,883,398.39	43,977,595.57
17	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,404,744.23	7,052,873.12
18	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,404,744.23	7,052,873.12
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,699,827.02	24,295,082.79
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,295,082.79	31,347,955.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2021 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	4,405,291,861.00	0	0	20,378,191.00	0	0	-371,621,171.08	4,054,048,880.92
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	0	0	0	0	0	0	-243,534,002.38	-243,534,002.38
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,405,291,861.00	0	0	20,378,191.00	0	0	-615,155,173.46	3,810,514,878.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,912,300.00	24,283,928.09	
2	НИЙТ ОРЛОГО	675,833,687.00	647,877,889.45	(27,955,797.55)
2.1	Өөрийн орлого	631,833,687.00	624,651,389.45	(7,182,297.55)
	2.1.1 Дулаан үйлдвэрлэлийн орлого	597,702,087.00	585,845,621.45	(11,856,465.55)
	2.1.2 Халуун усны орлого	9,600,000.00	8,677,000.00	(923,000.00)

	2.1.3	Худгийн орлого	5,400,000.00	4,421,039.00	(978,961.00)
	2.1.4	Хог хаягдлын орлого	4,800,000.00	10,618,450.00	5,818,450.00
	2.1.5	Түрээсийн орлого	1,200,000.00	1,200,000.00	-
	2.1.6	Шугам, сүлжээний цэвэр ус хангамжийн орлого	13,131,600.00	13,889,279.00	757,679.00
2.2	Гаднаас авах санхүүжилтын орлого		44,000,000.00	23,226,500.00	(20,773,500.00)
	2.2.1	Цэвэрлэх байгууламжийн засвар	44,000,000.00	17,600,000.00	(26,400,000.00)
	2.2.2	Тээл багийн гатлах онгоцны засвар		4,626,500.00	4,626,500.00
	2.2.3	Төвлөрсөн хогийн цэгийг түрж, цэгцлэх		1,000,000.00	1,000,000.00
3	НИЙТ ЗАРЛАГА		625,287,300.00	640,813,861.63	15,526,561.63
3.1	Цалин, хөлс		196,265,000.00	180,072,681.00	(16,192,319.00)
	3.1.1	Үндсэн цалин	196,265,000.00	180,072,681.00	(16,192,319.00)
3.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		26,495,775.00	27,405,066.49	909,291.49
3.3	Ашиглалтын зардал		74,215,500.00	93,013,802.80	18,798,302.80
	3.3.1	Цахилгааны зардал	59,995,500.00	59,931,752.80	(63,747.20)
	3.3.2	Түлш, шатахууны зардал	14,220,000.00	33,082,050.00	18,862,050.00
3.4	Түүхий эд, бараа материалын зардал		71,780,888.00	87,126,415.00	15,345,527.00
	3.4.1	Сэлбэг хэрэгслийн зардал	6,392,000.00	14,597,240.00	8,205,240.00
	3.4.2	Нүүрсний зардал	48,175,488.00	61,471,825.00	13,296,337.00
	3.4.3	Бичиг хэргийн зардал	601,000.00	577,950.00	(23,050.00)
	3.4.4	Шуудан, холбоо, интернэтийн зардал	860,400.00	718,500.00	(141,900.00)
	3.4.5	Хангамжийн материалын зардал	5,832,000.00	5,675,250.00	(156,750.00)
	3.4.6	Хоолны зардал	9,920,000.00	4,085,650.00	(5,834,350.00)
3.5	Хөдөлмөр хамгааллын зардал		8,901,000.00	8,142,000.00	(759,000.00)
	3.5.1	Нормын хувцас	7,701,000.00	6,612,000.00	(1,089,000.00)
	3.5.2	Хордлого тайлах бүтээгдэхүүн	1,200,000.00	1,530,000.00	330,000.00
3.6	Эд хогшил, урсгал засварын зардал		70,012,300.00	57,615,540.00	(12,396,760.00)
	3.6.1	Урсгал засварын зардал	60,912,300.00	39,645,200.00	(21,267,100.00)
	3.6.2	Багаж, хэрэгсэл худалдан авах зардал	9,100,000.00	17,970,340.00	8,870,340.00
3.7	Томилолтын зардал		1,190,000.00	630,000.00	(560,000.00)
	3.7.1	Дотоод албан томилолтын зардал	1,190,000.00	630,000.00	(560,000.00)
3.8	Бүсдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал		152,994,687.00	159,231,036.23	6,236,349.23
	3.8.1	Нүүрс тээврийн зардал	114,099,840.00	105,031,470.00	(9,068,370.00)
	3.8.2	Сургалтын зардал	1,810,000.00	1,632,100.00	(177,900.00)
	3.8.3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	35,324,847.00	52,417,466.23	17,092,619.23
	3.8.4	Хяналт шинжилгээ, байгаль орчны зардал	1,760,000.00	150,000.00	(1,610,000.00)
3.9	Нийгмийн хамгаалал		20,511,400.00	13,955,893.00	(6,555,507.00)
	3.9.1	Дотоод журмын дагуу олгох тэтгэмж, тусламж	1,800,000.00	1,836,000.00	36,000.00
	3.9.2	Шилдэг ажилчдын урамшуулал	8,320,000.00	5,297,250.00	(3,022,750.00)
	3.9.3	Идэвхижүүлэлтийн зардал	2,000,000.00	2,000,000.00	-
	3.9.4	Орон нутгийн тохижилт үйлчилгээ	8,391,400.00	4,822,643.00	(3,568,757.00)
3.1	Бусад зардал		2,920,750.00	13,621,427.11	10,700,677.11
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		60,458,687.00	31,347,955.91	29,110,731.09
5	Нийт ажиллагсад		28	28	

	5.1	Удирдах ажилтан	1	1	
	5.2	Гүйцэтгэх ажилтан	18	18	
	5.3	Үйлчлэх ажилтан	9	9	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын зорилго нь төвлөрсөн дулааны шугамд холбогдсон ААН, байгууллага, айл өрхүүдийг дулааны эрчим хүчээр найдвартай, тасралтгүй хангах, дулаан дамжуулах юм.

Байгууллагын үндсэн чиг үүрэг нь дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар тасралтгүй хангахад оршино. Тус байгууллагын дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар тасралтгүй хангах, цэвэр, бохир ус хангамжийг бий болгох, цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах, ариутгах, сумын төвийн тохижилт болон хуурай хог хаягдлыг төвлөрүүлэх, зайлуулахаас гадна ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг явуулж болно хэмээн тодорхойлсон байна. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байгаа бөгөөд өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа болно.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь Хутаг-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор 2014 онд байгуулагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй. ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах ...” гэсэн заалттай нийцэж байна.

Үүсгэн байгуулагч болох сумын ИТХ-аас ТУЗ-ийн бүрэлдэхүүн болох гишүүдийг, гүйцэтгэх захирлыг сумын Засаг дарга томилж байгаа нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, 20.1.13, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5, ИТХ-аар баталсан байгууллагын дүрмийн 5.10.4, 6.4-д заасантай нийцэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын “илчит хутаг” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлан бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн

байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156.4 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,295.1	31,347.9	7,052.8
Авлага	19,913.2	15,632.5	(4,280.7)
Бараа материал	24,447.3	21,875.3	(2,572.0)
Урьдчилж төлсөн зардал		2,100.0	2,100.0
Үндсэн хөрөнгө	3,987,616.3	3,792,223.8	(156,684.1)
Нийт хөрөнгө	4,056,272.2	3,863,179.6	(195,392.6)
Өр төлбөр	2,223.3	52,664.7	48,469.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,054,048.9	3,810,514.9	(243,534.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,056,272.2	3,863,179.6	(195,392.6)

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь Хаан банкны харилцах дансанд байгаа 27,198.6 мянган төгрөг, Төрийн банкны харилцах дансанд байгаа 4,149.3 мянган төгрөг тус тус бүрдүүлж байна.

Авлагыг үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад тайлант онд 4,280.7 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа нь өмнөх онд үүссэн дулааны хөнгөлөлтийн үлдэгдэл авлага орсонтой холбоотой. Тайлант онд үүссэн 15,632.5 мянган төгрөгийн авлагын 7,931.9 мянган төгрөгийг ажилчдаас авах авлага, 7,881.9 мянган төгрөгийг дансны авлага эзэлж байна.

Бараа материал дансны үлдэгдэл тайлант онд 21,875.3 мянган төгрөг болж буурсан нь худалдан авалтаасаа өндөр зарцуулалт хийсэнтэй холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэл болох 21,875.3 мянган төгрөгийн 57,6 мянган төгрөг хүнсний материал, 6,936.1 мянган төгрөгийн нүүрс, 1,031.8 мянган төгрөгийн шатахуун, 13,850.8 мянган төгрөгийн хангамжийн материал үлдэгдэлтэй байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд аудитын үйлчилгээний төлбөр болох 2,100.0 мянган төгрөгийг үлдэгдэл байгаа бөгөөд тайлант онд давхардаж гүйлгээ хийгдсэний 2,100.0 мянган төгрөгийг тус дансанд тусгасан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь тайлант оны элэгдэлтэй холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 48,469.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь тайлант онд тус байгууллагад орсон татварын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн актын дүнтэй холбоотой.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлант өртөг зардлын талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор нүүрс, нүүрс тээврийн зардал болон дулааны үйлдвэр дээр гарч байгаа цахилгаан эрчим хүчний зардлуудыг оруулсан байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээс зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг хэрхэн зөвшөөрч тусгах нь тодорхой бус байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагааны орлогоос 631,833.6 мянган төгрөгийг, ОНХС-аас 44,000.00 мянган төгрөгийг нийт зарлагыг 675,833.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж ИТХ-аар батлуулсан байна.

Тус байгууллага нь эрх барих дээд байгууллага болох сумын ИТХ-аар санхүүгийн төлөвлөгөөгөө батлуулан, түүний биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй. “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь өөрийн орлогоор санхүүждэг.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвөөр 675,833.7 мянган төгрөгийн орлого төлөвлөснөөс гүйцэтгэлээр 647,877.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Төсөвлөгдсөнөөр Орон нутгийн хөгжлийн сангаас тус үйлдвэрийн газрын цэвэрлэх байгууламжийн шүүрүүлэх талбайн засварын ажилд 44,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос тайлант онд 17,600.0 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 640,813.9 мянган төгрөг буюу 15,526.6 мянган төгрөгөөр өссөн байгаа нь үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор шатахуун, нүүрс тээвэр болон нүүрсний үнэ өссөнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

“Илчих хутаг” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр бусад үзүүлэлт буюу тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 675,833.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,137.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага цалингийн зардлыг 16,192.3 мянган төгрөгөөр, цахилгааны зардлыг 63.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн ч зарлага нийт дүнгээрээ 15,526.5 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч хөрөнгө зарцуулахдаа холбоотой нийт 9 удаагийн 4,721.2 мянган төгрөгийн мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалтыг зөрчин нийт 800.0 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хуулийн заалтыг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 -д заасан заалттай нийцээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон нийт 2,261.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 206,637.4 мянган төгрөгийн 7 албан шаардлага, 90,247.1 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэнд Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 19/22, 2022 оны 09 дүгээр сарын 39/22 тоотой хариу ирүүлжээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2,261.3	3	2,261.3	100
Албан шаардлага	7	206,637.4	7	206,637.4	100
Зөвлөмж	6	90,247.1	6	90,247.1	100
Нийт дүн	16	299,145.8	16	299,145.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аж ахуй нэгж байгууллагын борлуулсан бүтээгдэхүүний өртгийг НБББББ-ийн дагуу бүртгэж тайлагнасан эсэхэд анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 198.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 198.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нийт 24,826.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,589.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 17,515.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 0.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- Шатахууны зардлаас анхан шатны баримтгүй нийт 1,834.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй байна,
- Нийт 755.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

- Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй,
- Бараа материалын тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.5, НББ-ийн тухай хуулийн 12.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах цалингийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тооцоогүй нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртгийг Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Бараа материалын тодруулга дахь үндсэн түүхий эд материал дансны оны энхий үлдэгдэл, нярав тайлангаас зөрүүтэй	1	198.0					1	198.0				
Дүн	1	198.0					1.	198.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй	1				1							
Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах цалингийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тооцоогүй	1						1					
Шатахууны зардлаас анхан шатны баримтгүй нийт 1,834.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан	1	1,834.5	1	1,834.5								
Бараа материалын тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй	1	17,515.4			1	17,515.4						
Нийт 755.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дахь	1	755.0	1	755.0								

заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.												
Дүн	5	20,104.9	2	2,589.5	2	17,515.4	1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч хөрөнгө зарцуулахдаа холбоотой нийт 9 удаагийн 4,721.2 мянган төгрөгийг цахим хуудсанд байршуулаагүй	1				1	4,721.5		
Дүн	1	4,721.5			1	4,721.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалтыг зөрчин нийт 500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	500.0	1	500.0				
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	1	0.00					1	0.00
Дүн	2	500.0	1	500.0			1	0.00
Нийт дүн	3	5,221.2	1	500.0	1	4,721.5	1	00